

БНХАУ-ЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ЗӨВЛӨЛТИЙН ЭРДЭМТДИЙН ШИНЭ БҮТЭЭЛ

**Государственный строй Китайской
Народной Республики, Отв. ред
Л. М. Гудошников М., Наука, 1988, 232 стр.**

Зөвлөлтийн хятад судлаач эрдэмтэд «БНХАУ-ын төрийн байгуулалт» хэмээх нэгэн сэдэвт хамтын бүтээлийг туурвилаа.

Уг номын оршилд «...Хятадын ард түмэн өнөөгийн өөрчлөлтөөрөө 60—70-аад оны үед бий болсон улс орныхоо хөгжлийн саад бэрхшээлийг даван туулж, дэлхийн социализмын туршлагын нийтийн сан хөмрөгт чухал хувь нэмэр орууллаа. БНХАУ дахь шинэтгэл нь зөвхөн үндэсний ач холбогдолтой төдийгүй, социалист болоод социалист бус ертөнцийнхний өргөн сонирхлыг татаж байна... Бидний анхаарлыг татсан аугаа их социалист хөршийн маань хөгжлийн асуудлуудад төрийн байгуулалтыг судлах явдал онцгой байр суурийг эзэлдэг юм» (3 дахь тал) гэж дурдаад зохиолын эхний бүлэгт (5-10 дахь тал) Хятадад ардын ардчилсан төр үүсэн тогтносон үйл явц буюу хувьсгалын анхны бааз суурь бий болж байсан 1920-иод оны дунд үеэс БНХАУ байгуулагдсан 1949 он хүртлэх үеийн үйл явдлыг товч өгүүлжээ.

Хятадад төрийн шинэ байгуулалт буй болох үйл явц нь тайван замаар бус харин урт удаан хугацааны туршид үргэлжилсэн иргэний дайн (1925—1937), японы түрэмгийлэгчдийг эсэргүүцэх дайны (1932-1945) хүнд бэрх жилүүдэд явагдаж байснаараа нэлээд өвөрмөц онцлогтойг анхаарахгүй байж болохгүй юм. Иймээс ч Хятадад иргэний дайны гал ид дүрэлзэж байсан 20-иод оны сүүлч 30-аад оны эхээр чөлөөлөгдсөн районуудад ХКН-ын удирдлагаар хувьсгалт засгийн анхны хэлбэр зөвлөл (Зөвлөлт Бүгд Найрамдах Хятад Улс) бий болж, тэр нь 1931—1936 оны хооронд Японы империалистуудын түрэмгийлэх аюул занал өсөн нэмэгдсэн нөхцөлд Зөвлөлт Бүгд Найрамдах Ард Улсын хэлбэрт шилжиж хөрөнгөтөн, феодал, газрын эздийг өөртөө хэсэг хугацаагаар татаж чаджээ. Харин 1937 онд ХКН, гоминьдантай хамтарч Японы түрэмгийллийг эсэргүүцсэн нэгдмэл фронт байгуулснаар Зөвлөлт Бүгд Найрамдах Ард Улс нь Ардчилсан Бүгд Найрамдах Улс хэмээх засаглалын шинэ хэлбэрт шилжин орсон байна. Гагцхүү 1949 оны 10 дугаар сард БНХАУ-ыг тунхагласнаар Хятадад өнөөгийн ардын ардчилсан төр буй болжээ. Зохиогчид ардын ардчилсан төр улс үүсэх энэхүү үйл явцыг бүхэлд нь хөгжлийн диалектик уялдаатайгаар авч үзсэн бөгөөд тухайн үеийн төр, олон нийтийн байгууллага, сонгуулийн систем зэрэг нь улс орны нийгэм улс төрийн амьдралд ямар шуухан үүрэг роль гүйцэтгэж байсныг тодорхой баримтаар харуулсан байна.

Номын хоёрдугаар бүлэгт (15—34 дэх тал) 1931 онд баталсан Зөвлөлт Бүгд Найрамдах Хятад Улсын үндсэн хуулиас 1982 онд батлагдсан БНХАУ-ын шинэ үндсэн хууль хүртэлх, хятадын социалист төрийн үндсэн хуулийн түүхэн хөгжил, үндсэн хуулиудын үзэл санаа,

үүрэг, зорилт, тэдгээрийн шинж чанарыг өөр хооронд нь харьцуулан, задлан шинжилж шүүмжлэлтэйгээр авч үзжээ. Тухайлбал, уг номыг зохиогчдын үзэж байгаагаар «...1954 оны үндсэн хууль нь үндсэн агуулгаараа улс орны хөгжил дэвшилд чухал алхам болсон...» (21 дэх тал) бол «соёлын хувьсгал»-ын нөлөөгөөр буй болсон 1975 оны үндсэн хууль, түүний дараахь 1978 оны үндсэн хуулиуд нь дэвшилтэт шинж чанараараа түүнээс алхам ухарсан байна. Харин 1982 оны үндсэн хуулийг 1975, 1978 оны үндсэн хуулиудтай харьцуулбал илэрхий дэвшилттэй (34 дахь тал) бөгөөд үүгээрээ ч 1954 оны үндсэн хуульдаа нэлээд ойр дөт юм.

«БНХАУ-ын нийгэм-эдийн засгийн байгуулал» хэмээх гурав дахь бүлэг (35—96 дахь тал) нь өнөөгийн Хятадын нийгэм-эдийн засгийн амьдралын дүр төрхийг тодорхой баримтаар харуулсан нэлээд сонирхолтой хэсэг юм. Энэ хэсэгт БНХАУ-д эдийн засгийн системийн шинэтгэл хийгдэх болсон учир шалтгаан, шинэтгэлийн мөн чанар, Хятадын эдийн засаг дахь олон хэвшил, Хятадын нийгэм дэх өмчийн ялгааг тодорхойлж, хятадын эдийн засгийн шинэтгэлийн явцыг цаг хугацааны нь хувьд үечилж авч үзсэн нь уншигч, судлаачдад системтэй нэгэн цогц ойлголт өгөхөд нэлээд дөхөмтэй болжээ. Нөгөөтэйгүүр хот суурин газар болоод хөдөө орон нутгуудад явагдсан эдийн засгийн системийн шинэтгэлийг өөр хооронд нь харьцуулж, хослуулан авч үзсэнийг тэмдэглэвэл зохилтой.

Энд зохиогчид «нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн шатанд Хятадын нийгмийн ангийн бүтэц нэлээд нарийн түвэгтэй болох»-ыг (73 дахь тал) тэмдэглээд 1982 оны байдлаар БНХАУ-ын эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн бүтцэд ажилчин, албан хаагчдын эзлэх хувийн жин 25,0% (түүнээс улсын секторт 19,5%, хамтын секторт 5,5% хотын гар үйлдвэрлэгчид, хувийн аж ахуйтан 0,3%, тариачид 74,7% 73 дахь тал) байгааг харуулжээ.

Ийнхүү хятадын нийгмийн хүн амын давхаргын зонхилох хэсгийг урьдын адил тариачид эзэлж байгаа боловч сүүлийн жилүүдэд БНХАУ-д аж ахуйн системийн шинэтгэл явагдаж, шинжлэх ухаан техник хөгжиж үйлдвэр аж ахуйн газар олноор бий болох болсны улмаас ажилчин ангийн эгнээ өсөх хандлагатай болсныг зохиогчид тэмдэглэжээ. Мөн хэсэгт засаг төр, улс төрийн намууд, нэгдмэл фронт болон олон нийтийн нийгмийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар өгүүлсэн байна.

Номын дөрөвдүгээр бүлэг (112—130 дахь тал) нь бүхэлдээ Хятадын нутаг дэвсгэрийн зохион байгуулалт хийгээд үндэстний цөөнхийн газар нутгийн зохион байгуулалтын асуудалд зориулагджээ. 1949 онд БНХАУ байгуулагдсан цагаас хойш эдүгээг хүртэл Хятадын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн зохион байгуулалт хэрхэн өөрчлөгдөж, хувьсаж ирсэн түүхэн явцыг зохиогчид судалгааны материалд түшиглэн тодорхой өгүүлж холбогдох хүснэгт сэлтийг хавсаргажээ. Уг хэсэгт 1954 он, 1982 оны үндсэн хуулиудад тусгагдсан засаг захиргаа нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын талаарх зүйл ангиудыг (113, 123 дахь тал) харьцуулж, «засаг захиргааны онцгой район» болох Гонконг, Аоминь (Макао)-ы асуудал (121 дэх тал) 1984 онд батлагдсан БНХАУ-ын Үндэстний автономит районы тухай хууль (124 дэх тал) зэрэгт дүн шинжилгээ хийж Хятадын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн

зохион байгуулалтын үйл явц нь бүрэн төгс дуусаагүй цаашид үргэлжлэх (217 дахь тал) болохыг тодорхойлжээ.

«Иргэний хууль дүрмийн үндсүүд» бүлэгт (131— 139 дэх тал) БНХАУ-ын иргэн; иргэний үндсэн эрх, үүргийн тухайд өгүүлсэн байна. 1980 онд «БНХАУ-ын иргэний тухай хууль» анх удаа батлагдсан нь цаг хугацааны хувьд ихээхэн хожуу ч нийгмийн хөгжлийн зүй ёсны шаардлагын улмаас бий болсон юм. Нийгэм хөгжихийн хэрээр нийгмийн гишүүдийн өөр хоорондын харьцаа, гишүүдээс нийгэмтэйгээ харьцах харилцааны хэв хэмжээг зохицуулах тийм хууль зүйн дүрмүүд хэрэгцээтэй болов гэдгийг зохиогчид онцлон тэмдэглэжээ. Мөн хэсэгт 1982 оны үндсэн хуульд тусгагдсан БНХАУ-ын иргэдийн үндсэн эрх, үүргийн тухай тодорхой дурдав.

Уг хамтын бүтээлийн сүүлчийн бүлэг (150—216 дахь тал) болох «Төрийн байгууллагуудын систем» нь нэлээд томоохон хэсэг бөгөөд БНХАУ-ын төрийн байгууллагуудын системийн онцлог, сонгуулийн систем, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал түүний Байнгын Хороо, БНХАУ-ын дарга, БНХАУ-ын Төрийн зөвлөл, Цэргийн Төв Зөвлөл, Засаг төр болон Захиргааны орон нутгийн байгууллагууд, Шүүх байгууллага болон прокурорын байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг роль, үйл ажиллагааны нь тухайд дэлгэрэнгүй өгүүлжээ.

БНХАУ-д төрийн байгууллагын үндсэн дөрвөн хэлбэр байх бөгөөд тэдгээрт; засаг төр, захиргаа, шүүх, прокурор багтдаг байна. Тэдгээр нь төрийн байгууллагын нэгдмэл системийг бүрдүүлдэг ба үндсэн хуулиндаа «төрийн бүтэц» хэмээн тодорхойлогджээ. Ер нь БНХАУ-д өнөө үед төрийн аппарат түүний бүтэц, боловсон хүчний бүрэлдэхүүнийг боловсронгуй болгоход ихээхэн хүч чармайлт тавьж буйг (218 дахь тал) уг номыг зохиогчид тэмдэглэжээ.

Зөвлөлтийн Хятад судлаачид эрдэмтдийн туурвисан энэхүү нэгэн сэдэвт хамтын бүтээл нь БНХАУ-ын төрийн байгуулалтын хөгжлийн үйл явц, түүний хөгжлийн орчин үеийн өвөрмөц онцлогийг нээн харуулахыг зорьсон нэлээд чамбай бүтээл юм.

Уг ном нь дан ганц эрдэм шинжилгээ судалгааны зориулалттай бус харин өргөн олон нийт уншигч, түүний дотор нам, улс төрийн ажилтан, хуулийн байгууллагын болоод их, дээд сургуулийн нийгмийн ухааны чиглэлийн багш, оюутан ер нь Хятадын асуудлыг сонирхдог хүн бүрийн гарын авлага болохуйц сонирхолтой шинэ бүтээл болсныг тэмдэглэвэл зохино.

Ч. Эрдэнэбаяр